



НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2019 оны 01 сарын 31 өдөр

Дугаар А/21

Улаанбаатар хот

“Нийгмийн даатгалын үйлчилгээний
маркетингийн дунд хугацааны хөтөлбөр”
батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Нийгмийн даатгалын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 4, Засгийн газрын 2014 оны 354 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Нийгмийн даатгалын байгууллагын дүрэм”-ийн 3.1.5, 3.2.4, 3.2.6 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Нийгмийн даатгалын үйлчилгээний маркетингийн дунд хугацааны хөтөлбөр (2018-2022)”-ийг хавсралтаар баталсугай.

2. “Нийгмийн даатгалын үйлчилгээний маркетингийн дунд хугацааны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээг үйл ажиллагааны төлөвлөгөөндөө жил бүр тусган биелэлтийг ханган, энэ асуудлаар төрийн болон төрийн бус, олон улсын байгууллагууд, холбогдох бусад байгууллагатай хамтран ажиллахыг Тамгын газар газар (Н.Эрдэнэжав), Сургалт, олон нийт, хамтын ажиллагааны газар (Д.Цэцэгбадам), хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөрөнгийн эх үүсвэрийг үйл ажиллагааны зардлын жил бүрийн төсөвт тусган батлуулахыг Бодлогын хэрэгжилт, судалгааны газар (Ц.Ганцэцэг), хөтөлбөрийн хэрэгжилтэд хагас жил тутам үнэлгээ хийж, холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Дотоод аудит, мониторингийн газар (Ц.Алтангэрэл)-т тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дэд дарга (Г.Саран)-д даалгасугай.


ДАРГА



Д.ЗОРИГТ

1000072

Нийгмийн даатгалын ерөнхий газрын
даргын 2019 оны 01 дүгээр сарын 31
өдрийн А/21 дугаар тушаалын хавсралт



НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙГАЗАР

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ МАРКЕТИНГИЙН ДУНД ХУГАЦААНЫ ХӨТӨЛБӨР

(2019-2022 он)

УЛААНБААТАР ХОТ
2019 ОН

АГУУЛГА

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙГМИЙН ДААТГАЛЫН БАЙГУУЛЛАГЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ	2
1.1. Нийгмийн даатгалын зарим үндсэн үзүүлэлт, статистик мэдээлэл.....	2
1.2. Нийгмийн даатгалын салбарын нөхцөл байдлын дүн шинжилгээ (SWOT)..	5
ХОЁРДУГААР БҮЛЭГ. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, БАРИМТЛАХ ЗАРЧИМ, СТРАТЕГИ	8
2.1. Хөтөлбөрийн зорилго, зорилт	8
2.2. Хөтөлбөрийн баримтлах зарчим, стратеги	9
ГУРАВДУГААР БҮЛЭГ. ХӨТӨЛБӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ	10
3.1. Нийгмийн даатгалын зорилтот бүлэг, мэдээлэл түгээх арга зам	10
3.2. Зорилтот бүлгүүдэд мэдээлэл хүргэх суваг, арга хэлбэр	11
3.3. Олон нийтэд чиглэсэн үйл ажиллагаа	14
3.4. Нийгмийн даатгалын байцаагч, ажилтнуудад чиглэсэн үйл ажиллагаа	15
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ МАРКЕТИНГИЙН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	15
4.1. Нөөц, эх үүсвэр	15
4.2. Зохион байгуулалт	16
ТАВДУГААР БҮЛЭГ. НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ МАРКЕТИНГИЙН ХӨТӨЛБӨРИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ	16
ХАВСРАЛТ 1. НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ МАРКЕТИНГИЙН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	17
ХАВСРАЛТ 2. НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ МАРКЕТИНГИЙН ХӨТӨЛБӨРИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ СУУРЬ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	24

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙГМИЙН ДААТГАЛЫН БАЙГУУЛЛАГЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

1.1. Нийгмийн даатгалын зарим үндсэн үзүүлэлт, статистик мэдээлэл

Монгол Улс зах зээлийн баримжаатай нийгэм, эдийн засгийн харилцаанд шилжсэнээр 1994 онд Нийгмийн даатгалын багц хуулийг, 1999 онд “Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар 2021 он хүртэл баримтлах үндсэн чиглэл”, “Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хууль”, 2015 онд Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого”-ыг тус тус баталж ажил олгогч болон даатгуулагчаас төлсөн шимтгэлийн орлогоор тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгодог тогтолцоог нэвтрүүлж эхэлснээс хойш 23 жилийн хугацаа өнгөрч байна.

Нийгмийн даатгалын байгууллага нь Нийгмийн даатгалын тухай багц хуулиудыг хэрэгжүүлэх, сурталчлах, хамралтыг нэмэгдүүлэх, нийгмийн даатгалын сангийн орлогыг бүрдүүлэх, нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлыг хуульд заасан хугацаанд тогтоон олгох, нийгмийн даатгалын үйлчилгээнд дэвшилтэт хэлбэр нэвтрүүлэх, тооцоолол судалгаа хийх, орон нутгийн нийгмийн даатгалын хэлтсийн үйл ажиллагаанд хяналт тавих, арга зүйн удирдлагаар хангах үндсэн чиг үүрэгтэйгээр ажиллаж байна.

Нийгмийн даатгалд 2013 онд 35.5 мянган, 2014 онд 39.5 мянган, 2015 онд 41.6 мянган, 2016 онд 43.1 мянган, 2017 онд 43.6 мянган аж ахуйн нэгж байгууллага, 2013 онд 803.9 мянган, 2014 онд 832.9 мянган, 2015 онд 799.8 мянган, 2016 онд 799.6 мянган, 2017 онд 836.5 мянган албан журмын даатгуулагч, 2013 онд 148.2 мянган, 2014 онд 185.7 мянган, 2015 онд 189.2 мянган, 2016 онд 228.5 мянган, 2017 онд 199.1 мянган сайн дурын даатгуулагч хамрагдсан байна.

Хүснэгт 1. Нийгмийн даатгалд хамрагдсан ажил олгогч, даатгуулагчдын тоо

Үзүүлэлт	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он
Ажил олгогч	35 461	39 496	41 648	43122	43580
Албан журмын даатгуулагч	803 887	832 892	799 798	799 558	836 487
Сайн дурын даатгуулагч	148 168	185 668	189 238	228 480	199 143

Хүснэгт 2. Нийгмийн даатгалын сангийн орлого

Үзүүлэлт	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он
Ажил олгогчийн төлсөн шимтгэл	528.1	587.6	607.0	660.6	753.2
Даатгуулагчийн төлсөн шимтгэл	439.5	491.0	504.4	577.5	679.1
Улсын төсвөөс олгосон хөрөнгө	264.6	253.3	292.6	494.9	570.2
Бусад орлого	50.9	62.7	75.8	74.5	111.7
ДҮН	1 283.1	1 394.6	1 480.0	1 807.5	2 114.2

Нийгмийн даатгалын санд 2017 онд ажил олгогчийн төлсөн шимтгэлээс 753.2 тэрбум төгрөг, даатгуулагчийн төлсөн шимтгэлээс 679.1 тэрбум төгрөг, улсын төсвөөс 570.2 тэрбум төгрөг, сангийн чөлөөт үлдэгдлийг арилжааны

банкинд байршуулсны хүүгийн болон торгууль, алдангийн орлогоос 111.7 тэрбум төгрөг, нийт 2 114.2 тэрбум төгрөгийн орлого бүрдүүлсэн нь өмнөх оныхоос 831.4 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 3. Нийгмийн даатгалын сангаас үйлчилгээ авсан даатгуулагчдын тоо, зарцуулсан хөрөнгө

Нийгмийн даатгалын сан	2014 он		2015 он		2016 он		2017 он	
	Даатгуулагчийн тоо /мян.хүн/	Зарцуулсан хөрөнгө /тэрбум.төгрөг/	Даатгуулагчийн тоо /мян.хүн/	Зарцуулсан хөрөнгө /тэрбум.Төгрөг/	Даатгуулагчийн тоо /мян.хүн/	Зарцуулсан хөрөнгө /тэрбум.төгрөг/	Даатгуулагчийн тоо /мян.хүн/	Зарцуулсан хөрөнгө /тэрбум.төгрөг/
Тэтгэврийн	338.8	985.5	356.7	1 171.8	376.8	1 303.8	388.6	1 417.4
Тэтгэмжийн	178.3	78.5	180.3	87.0	182.0	92.3	194.4	100.2
ҮОМШӨ-ний	11.4	29.6	10.6	30.1	10.0	28.9	9.6	29.3
Ажилгүйдлийн ЭМД-ийн	16.3	17.8	18.7	22.4	23.2	31.6	21.2	34.7
Нийт	4 996.9	1 286.2	5 608.9	1 507.7	6 300.1	1 694.0	7 474.6	1 869.7

2017 оны байдлаар нийгмийн даатгалын сангийн зарлагын 75.8 хувийг тэтгэврийн даатгалын сан, 5.4 хувийг тэтгэмжийн даатгалын даатгалын сан, 1.6 хувийг Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сан, 1.9 хувийг ажилгүйдлийн даатгалын сан, 15.4 хувийг эрүүл мэндийн даатгалын сан тус тус эзэлж байна.

1.1.1. Нийгмийн даатгалын сангийн мэдээлэл

Тэтгэврийн даатгалын сан: Тайлангийн жилд тэтгэврийн даатгалын сангаас өндөр насны, тахир дутуугийн, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авч байгаа 371.2 мянган тэтгэвэр авагчид 1 309.5 тэрбум төгрөг, 17.4 мянган цэргийн албан хаагчийн тэтгэвэрт 106.4 тэрбум төгрөг тус тус зарцуулсан байна.


Нийгмийн даатгалын тухай хууль хүчин төгөлдөр болохоос өмнө буюу 1995 оноос өмнө тэтгэвэр тогтоолгосон 62.3 мянган тэтгэвэр авагчийн тэтгэвэрт 209.1 тэрбум төгрөг, “Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль”-иар тэтгэвэр тогтоолгосон 17.4 мянган тэтгэвэр авагчид 106.4 тэрбум төгрөг тус тус зарцуулсан нь нийт тэтгэврийн сангийн зарлагын 22.2 хувийг эзэлж байна.

Хүснэгт 4. Тэтгэвэр авагчдын тоо, олгосон тэтгэвэр (тэрбум төгрөгөөр)

Тэтгэврийн төрөл	2014 он		2015 он		2016 он		2017 он	
	Хүний тоо /мян.хүн/	Зарцуулсан хөрөнгө	Хүний тоо /мян.хүн/	Зарцуулсан хөрөнгө	Хүний тоо /мян.хүн/	Зарцуулсан хөрөнгө	Хүний тоо /мян.хүн/	Зарцуулсан хөрөнгө
Өндөр насны	241,9	724.8	255,6	867.8	268,9	973.7	282,6	1,065.6
Тахир дутуугийн	59,2	129.7	63,6	158.3	65,1	174.8	67,8	185.1
Тэжээгчээ алдсаны	21,7	49.9	21,3	54.5	20,9	57.5	20,7	58.8
Цэргийн	16,1	80.3	16,2	91.2	16,7	97.8	17,4	106.4
Нийт	338,9	984.7	356,7	1 171.8	371,6	1 303.8	388,5	1 415.9

Тэтгэвэр авагчдын тоо 2014-2017 онуудад жил бүр 102.3-аас 110.4 хувиар өссөн байна.

Дүрслэл 1. Тэтгэвэр авагчдын тоо



Тэтгэмжийн даатгалын сан: Тэтгэмжийн даатгалын сангаас 194.4 мянга орчим даатгуулагчдад 99.9 тэрбум төгрөгийн хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны, оршуулгын тэтгэмж олгов. Тэтгэмжийн даатгалын сангийн зарлага өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7.7 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Тэтгэмж авагчдын тоо, олгосон тэтгэмж

Тэтгэмжийн төрөл	2014 он		2015 он		2016 он		2017 он	
	Даатгуу-лагчийн тоо /мян.хүн/	Зарцуул-сан хөрөнгө	Даатгуу-лагчийн тоо /мян.хүн/	Зарцуул-сан хөрөнгө	Даатгуу-лагчийн тоо /мян.хүн/	Зарцуул-сан хөрөнгө	Даатгуу-лагчийн тоо /мян.хүн/	Зарцуул-сан хөрөнгө
Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж	112,4	12,095.7	109.1	12,351.0	110.5	12,772.9	123.3	16,138.7
Жирэмсний болон амаржсаны тэтгэмж	53,0	58,277.2	58.0	66,522.1	58.1	68,371.9	57.8	70,564.4
Оршуулгын тэтгэмж	12,9	8,055.3	13.2	8,153.5	13.3	11,118.9	13.3	13,295.0
Дүн	178.3	78,428.2	180.3	87,026.6	182.0	92,263.7	194.4	99,998.1

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сан: 2017 оны жилийн эцсийн байдлаар тахир дутуугийн болон тэжээгчээ алдсан 4.9 мянган тэтгэвэр авагчдын тэтгэвэрт 26.2 тэрбум төгрөг, хөдөлмөрийн чадвар түр алдсан 1098 даатгуулагчийн тэтгэмжид 595.6 сая төгрөг, хөдөлмөрийн чадвар нөхөн сэргээхтэй холбогдсон төлбөр, рашаан сувилалд ирж, буцах болон рашаан сувиллын зардалд 993.7 сая төгрөг, мөн тахир дутуу болсон даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлд 846.2 сая төгрөгийг тус тус уг сангаас санхүүжүүлсэн байна. Энэхүү зардал өмнөх оны мөн үеийнхээс 0.4 сая төгрөгөөр нэмэгджээ.

Хүснэгт 6. Тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авагчдын тоо, зарцуулсан хөрөнгө
(сая төгрөгөөр)

	2014 он		2015 он		2016 он		2017 он	
	Даатгуу-лагчийн тоо	Зарцуулсан хөрөнгө	Даатгуу-лагчийн тоо	Зарцуулсан хөрөнгө	Даатгуу-лагчийн тоо	Зарцуулсан хөрөнгө	Даатгуу-лагчийн тоо	Зарцуулсан хөрөнгө
Тахир дутуугийн тэтгэвэр	5378	24,884.1	4902	24,747.4	4573	24,100.4	4347	23,686.0
Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	611	2,355.1	593	2,408.9	579	2,534.4	568	2,477.8
ХЧТА-ны тэтгэмж	841	422.1	993	555.8	1009	580.8	1098	595.6
Хөдөлмөрийн чадвар нөхөн сэргээхтэй холбогдсон төлбөр	26	37.2	26	31.4	22	25.4	20	19.1
Рашаан сувиллын зардал	4498	785.1	4101	1,139.1	3840	1 059.1	3588	974.6
Урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал		164.2		383.1				706.6
Тахир дутуугийн тэтгэвэр авагчдын тэтгэврийн даатгалын шимтгэл		888.9		847.2		600.6		846.2
Дүн	11 354	29,536.7	10 615	30,112.9	10 023	28,900.7	9 621	29,305.9

Нийт зардлын 89.2 хувийг тахир дутуугийн болон тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагчдын тэтгэвэрт зарцуулав.

Ажилгүйдлийн даатгалын сан: 2017 онд ажилгүйдлийн даатгалын сангаас ажлаас халагдсан 21.2 мянган даатгуулагчийн тэтгэмжид 34.6 тэрбум төгрөг зарцуулсан байна. Ажилгүйдлийн тэтгэмж авагчдын тоо өмнөх оны мөн үеийнхээс 2050 хүнээр буурсан байна.

Хүснэгт 7. Ажилгүйдлийн даатгалын сангаас тэтгэмж авагчдын тоо, зарцуулсан хөрөнгө
(сая төгрөгөөр)

Ажилгүйдлийн даатгалын сан	2014 он		2015 он		2016 он		2017 он	
	Даатгуу-лагчийн тоо	Зарцуулсан хөрөнгө	Даатгуу-лагчийн тоо	Зарцуулсан хөрөнгө	Даатгуу-лагчийн тоо	Зарцуулсан хөрөнгө	Даатгуу-лагчийн тоо	Зарцуулсан хөрөнгө
Ажилгүйдлийн тэтгэмж	16 315	17,774.5	18 698	22,384.7	23 203	31,585.8	21 142	34,624.6
Сургалтын төлбөр							21	1.1
Дүн	16 315	17,774.5	18 698	22,384.7	23 203	31,585.8	21 153	34,625.7

1.2. Нийгмийн даатгалын салбарын нөхцөл байдлын дүн шинжилгээ (SWOT)

Дотоод	Давуу тал	Сул тал
		<p><i>Нийгмийн даатгалын тогтолцоо:</i></p> <p>- Нийгмийн даатгалын тогтолцоо үүсээд 76, шинэ тогтолцоонд шилжээд 23 жил болж байгаа учир олон жилийн мэдлэг, туршлага хуримтлуулсан. Монгол Улс нь нийгмийн даатгалын харьцангуй</p>

<p>сайн тогтолцоотой улс орны тоонд ордог.</p> <p><i>Хүний нөөцийн чадавхи:</i></p> <ul style="list-style-type: none"> - Нийгмийн даатгалын байгууллагын ажилтан нь төрийн албаны мэргэшлийн шалгалт болон нийгмийн даатгалын улсын байцаагчийн шалгалтыг өгдөг тул харьцангуй ур чадвар сайтай. <p><i>Үйлчилгээний хүртээмж:</i></p> <ul style="list-style-type: none"> - Нийгмийн даатгал нь хүний амьдралд тохиолдох жам ёсны болон гэнэтийн эрсдэлийн үед тэдний санхүүгийн эрсдэлийг хуваалцдаг учир нийгмийн бүх давхаргад хүрч үйлчилдэг. <p><i>Байгууллагын соёл:</i></p> <ul style="list-style-type: none"> - Нийгмийн даатгалын байгууллага нь эрхэм зорилго, алсын хараа, эрхэмлэх үнэ цэнийг тодорхойлсон. Нийгмийн даатгалын байгууллагын хүний нөөцийн өнөөгийн байдлын судалгаагаар нийгмийн даатгалын байгууллагын ажилтнууд нь байгууллагын соёлыг эергээр үнэлсэн. <p><i>Үйл ажиллагааны сайжруулалт:</i></p> <ul style="list-style-type: none"> - Нийгмийн даатгалын салбарт Чанарын удирдлагын тогтолцоо хэрэгжүүлж байгаатай холбогдуулан нийгмийн даатгалын үйл ажиллагаанд тасралтгүй сайжруулалт буюу тэтгэвэр, тэтгэмж, орлого шимтгэлийн процессын хөгжүүлэлт хийгдэж байна. <p><i>Програм хангамжийн хөгжүүлэлт:</i></p> <ul style="list-style-type: none"> - Нийгмийн даатгалын байгууллага нь мэргэжлийн багц програм хангамжууд ашигладаг. Мэдээллийн технологийн төв нь програм хангамжийн хөгжүүлэлтийг тогтмол хийдэг. 	<ul style="list-style-type: none"> - Шинэ ажилтан/ажилтны сургалт-хөгжлийг хангах нэгдсэн тогтолцоо байхгүй. <p><i>Цалин, урамшууллын тогтолцоо:</i></p> <ul style="list-style-type: none"> - Нийгмийн даатгалын байгууллагын байцаагч, ажилтны цалин төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээний шатлалыг мөрддөг. Ижил түвшний байгууллагуудтай харьцуулахад албан тушаалын зэрэглэлийг доогуур тогтоосон, урамшууллын тогтолцоо хэрэгждэггүй. Цалин, урамшууллын тогтолцоонд ажилтнууд сэтгэл дундуур байдаг. <p><i>Програм хангамжийн хөгжүүлэлт:</i></p> <ul style="list-style-type: none"> - Нийгмийн даатгалын багц програм хангамж хоорондын уялдаа холбоо, үйлдлийг сайжруулж ажилтнуудын гар ажиллагааг багасгах, бүтээмжийг нэмэгдүүлэх, цаашлаад иргэдэд түргэн шуурхай үйлчлэх нөхцөлийг улам сайжруулах шаардлагатай. <p><i>Сайн дурын даатгалын хамралт:</i></p> <ul style="list-style-type: none"> - Нийгмийн даатгалд сайн дурын хэлбэрийн хамрагдалт буурч байгаа. <p><i>Маркетинг:</i></p> <ul style="list-style-type: none"> - Олон нийтийн дунд нийгмийн даатгалын ач холбогдлын талаарх мэдлэг, мэдээлэл хангалттай биш байгаагаас нийгмийн даатгалын талаарх буруу ташаа мэдээлэл олон нийтийн дунд байдаг. - Олон нийтэд нийгмийн даатгалын талаарх мэдээлэл, сурталчилгаа хүргэх нэгдсэн бодлого байхгүй, хүний нөөц дутагдалтай, мэргэшээгүй. <p><i>Үйлчилгээний соёл:</i></p> <ul style="list-style-type: none"> - Хөндлөнгийн байгууллагуудын хийсэн судалгаанаас харахад нийгмийн даатгалын байгууллагын үйлчилгээний соёл буюу ажилтны харилцаа хандлага, орчин нөхцөлийг сайжруулах шаардлагатай.
--	--

	Боломж	Сөрөг хүчин зүйл
Гадаад	<p><i>Эрх зүйн орчин:</i></p> <ul style="list-style-type: none"> - Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого, Нийгмийн даатгалын багц хууль зэрэг эрх зүйн орчин бүрдсэн. 	<p><i>Хууль тогтоомжийн өөрчлөлт:</i></p> <ul style="list-style-type: none"> - Улс төрийн шийдвэрээр хууль тогтоомжид төлөвлөгдөөгүй өөрчлөлт, шинэчлэлт орох, хууль шинээр батлагдах, хүчингүй болох эрсдэлтэй.
	<p><i>Үйлчилгээний хүртээмж:</i></p> <ul style="list-style-type: none"> - Нийгмийн даатгал нь хүний амьдралд тохиолдож болзошгүй эрсдэлийн үед даатгуулагчид болон гэр бүлд нь нийгмийн даатгалын үйлчилгээг нийгмийн бүх давхарга, бүх насны хүнд хүрч үйлчилдэг. Олон нийт нийгмийн даатгалын талаарх мэдээллийг соргог хүлээн авдаг. 	<p><i>Олон нийтийн ойлголт:</i></p> <ul style="list-style-type: none"> - Олон нийтийн дунд төрийн байгууллагын нэр хүнд тааруу, хүнд суртал их, чирэгдүүлдэг гэсэн сөрөг ойлголт, хандлага байдаг.
	<p><i>Байгууллагын нэр хүнд:</i></p> <ul style="list-style-type: none"> - Нийгмийн даатгалын төв, орон нутгийн 33 байгууллагад 1478 ажилтантайгаар ажиллаж байна. Нийгмийн даатгалд 2.9 сая даатгуулагчийг хамруулж, давхардсан тоогоор 6.8 сая даатгуулагчид тэтгэвэр, тэтгэмж, зардал, төлбөрт 1.9 их наяд төгрөгийг зарцуулж байна. Байгууллагын нэр хүнд, даатгуулагчийн сэтгэл ханамж эерэг түвшинд байдаг. 	<p><i>Эдийн засгийн тогтворгүй байдал, хямралын нөлөөлөл:</i></p> <ul style="list-style-type: none"> - Улс орны эдийн засаг, улс төрийн шийдвэрээс хамаарч нийгмийн даатгалын сан алдагдалд орох эсэх, эрсдэлийн түвшин, тогтвортой байдал хамаардаг.
	<p><i>Хамтын ажиллагаа:</i></p> <ul style="list-style-type: none"> - Нийгмийн даатгалын тогтолцоог бэхжүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэх чиглэлээр олон улсын хамтын ажиллагааны байгууллагын дэмжлэг авах, хамтран ажиллах боломжтой. - Нийгмийн даатгалын харилцаанд оролцогч төр, ажил олгогч, даатгуулагч болон бусад байгууллагуудтай уялдаа холбоотой ажилладаг. 	<p><i>Төрийн байгууллага хоорондын уялдаа холбоо:</i></p> <ul style="list-style-type: none"> - Төрийн байгууллагын хоорондын ажлын уялдаа холбооноос хамаарч иргэд, даатгуулагчид олон шат дамжлагаар үйлчилгээ үзүүлэх, сэтгэл ханамжийг бууруулах тохиолдол байдаг. <p><i>Өрсөлдөөн:</i></p> <ul style="list-style-type: none"> - Арилжааны даатгалын компаниуд нь шийдвэр гаргагчид, олон нийтэд нийгмийн даатгалын тогтолцоог хувийн секторт шилжүүлэх байр сууринаас мэдээлэл түгээх байдал ихэссэн.

Нийгмийн даатгалын байгууллага нь “Бид даатгуулагчийнхаа итгэл найдвар, сэтгэл ханамжаар үнэлэгдэх нийгмийн даатгалын үйлчилгээг хүргэх” эрхэм зорилго, “Нийгмийн даатгалын байгууллага 2030 он гэхэд бүх нийтийн насан туршийн нийгмийн баталгааг хангахуйц чадамжтай, нийгмийн даатгалын цогц үйлчилгээ бүхий даатгагч болох” алсын хараагаа тодорхойлсон. Энэхүү эрхэм зорилго, алсын хараандаа өсөн дэвших эрмэлзэлтэй мэргэшсэн, чадварлаг, ёс зүйтэй хүний нөөцөд түшиглэн үйл ажиллагаагаа цаг үргэлжид сайжруулан,

түншлэл хамтын ажиллагааг дэмжин, харилцан үр ашигтай хамтран ажиллаж, сайн засаглалыг хэрэгжүүлэн хэрэгцээ шаардлагад нийцсэн чанартай үйлчилгээг даатгуулагчдад хүргэх чанарын бодлого дэвшүүлэн үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж байна.

Нийгмийн даатгалын статистикийн мэдээллээс харахад ажил олгогч, албан журмын даатгуулагчдын тоо жилээс жилд нэмэгдэж байгаа боловч 2017 онд сайн дурын даатгуулагчийн тоо өмнөх оныхоос 29.3 мянган хүнээр буурсан үзүүлэлттэй байна. Энэ олон нийтийн дунд ялангуяа хувиараа хөдөлмөр эрхлэгчид, малчдын нийгмийн даатгалын талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, ач холбогдлыг сурталчлан таниулах, даатгуулагчдын хамралтыг нэмэгдүүлэхэд зорилтот үйл ажиллагааг төрийн болон төрийн бус, олон улсын байгууллагатай хамтран зохион байгуулах хэрэгтэй байна.

Аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн 530 байцаагч, ажилтнуудыг хамруулан 2018 онд авсан судалгаанаас үйлчлүүлэгчид ээлтэй орчин нөхцөл бүрдүүлэх, ажилтнуудын харилцааны болон мэргэжлийн ур чадварыг сайжруулж, үйлчилгээний чанарыг дээшлүүлэх зайлшгүй шаардлага байгаа нь харагдсан.

Иймээс цаашид Улсын Их Хурал, Засгийн газрын баталсан бодлогын баримт бичиг, хөтөлбөрт заасан нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх ялангуяа сайн дураар даатгуулагчид, гадаадад ажиллаж амьдарч байгаа иргэдийн нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх, олон нийтийн дунд нийгмийн даатгалын ач холбогдлыг сурталчлан таниулах, үүний тулд иргэдийн нийгмийн даатгалд хамрагдах хэлбэр, хүн ам зүйн онцлогоор нь зорилтод бүлэгт хуваан, тэдэнд чиглэсэн үйл ажиллагааг үе шаттайгаар төлөвлөн хэрэгжүүлэх нь нийгмийн даатгалын байгууллагын өмнө тулгарч байгаа зорилт болж байна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, БАРИМТЛАХ ЗАРЧИМ, СТРАТЕГИ

2.1. Хөтөлбөрийн зорилго, зорилт

Нийгмийн даатгалын маркетингийн хөтөлбөрийн зорилго нь хүн амын нийгмийн даатгалын талаарх мэдлэг, хандлага, ойлголтыг дээшлүүлэх, төлөвшүүлэх, нийгмийн даатгалд даатгуулагчдын хамралтыг нэмэгдүүлэхэд оршино.

Дээрх зорилгод хүрэхэд дараах зорилтуудыг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Нийгмийн даатгалын зорилтот бүлэг тус бүрийг тодорхойлж, нийгмийн даатгалын зарчим, төрөл, түүний ач холбогдлын талаарх мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх мэдээллийн багцуудыг боловсруулах, тэднийг нийгмийн даатгалд хамруулах үйл ажиллагааг идэвхжүүлэх;
- Олон нийтэд нийгмийн даатгалын ач холбогдлыг ойлгуулан таниулах, нийгмийн даатгалд даатгуулах хандлагыг бий болгох зорилгоор мэдээлэл хүргэх сувгийг

тодорхойлох, сонгох, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, ажил олгогч, олон улсын хамтын ажиллагааны байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах, тэдний оролцоог нэмэгдүүлэх, хамтын ажиллагааг бэхжүүлэх;

- Нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллага, ажилтны зүгээс нийгмийн даатгалын үйлчилгээг олон нийт, даатгуулагчдад мэдээлэх, сурталчлан таниулах.

2.2. Хөтөлбөрийн баримтлах зарчим, стратеги

Нийгмийн даатгалын маркетингийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах зарчим, стратеги баримтална. Үүнд:

- Нийгмийн даатгалын зорилтот бүлэгт чиглэх:

Нийгмийн даатгалын зорилтот бүлгүүдийн мэдлэг, хандлага буюу зан үйл, ойлголтыг тодорхойлж, бүлэг тус бүрт маркетингийн аргачлалыг чиглүүлнэ.

- Оролцоог дэмжих:

Нийгмийн даатгалын маркетингийн үйл ажиллагаанд иргэд, олон нийт, хамтрагч талуудын идэвхтэй оролцоонд суурилан маркетингийн хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

- Шуурхай, үнэн зөв мэдээллээр хангах:

Нийгмийн даатгалын үйлчилгээний талаарх болон цагийн үеийн мэдээллийг үнэн зөв, шуурхай, найдвартай эх үүсвэрээс түгээнэ.

- Мэдээлэл энгийн, хялбар байх:

Олон нийтэд чиглэсэн мэдээлэл нь энгийн үг хэллэгээр ойлгомжтой хэлбэрээр илэрхийлэх буюу албан ёсны, хуулийн үг хэллэгээс зайлсхийнэ. Мэдээллийг хялбаршуулсан зураг, дүрслэл, инфографик, анимейшн, комик хуудас зэрэг арга хэрэгсэл ашиглана.

- Хүртээмжтэй байх:

Нийгмийн даатгалын талаарх мэдээллийг хүртээмжтэй, оновчтой хүргэх суваг сонгон хүргэнэ.

- Санал хүсэлт авах:

Үйлчлүүлэгчийн санал хүсэлтээ илэрхийлэх нөхцөлийг сайжруулах, эргэх холбоогоор хангах, санал хүсэлтэд дүн шинжилгээ хийж үйл ажиллагаагаа сайжруулна.

- Даатгуулагчид ээлтэй орчин бүрдүүлэх:

Нийгмийн даатгалын байгууллагаар үйлчлүүлж байгаа иргэд-даатгуулагч, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тав тухтай, ээлтэй орчин бүрдүүлэх, үйлчилгээний соёлыг дээшлүүлнэ.

- Үйлчилгээг сайжруулах:

Нийгмийн даатгалын үйлчилгээг даатгуулагчдад ойртуулах, цахим үйлчилгээг нэмэгдүүлэх, сурталчлан таниулна.

- Хяналт-шинжилгээ, үнэлгээг хийх:

Нийгмийн даатгалын маркетингийн хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээг тогтмол хийж, үр дүнд тулгуурлан маркетингийн цаашдын хэрэгжилтийг улам сайжруулах, чанарыг дээшлүүлнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ХӨТӨЛБӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

3.1. Нийгмийн даатгалын зорилтот бүлэг, мэдээлэл түгээх арга зам

Нийгмийн даатгалын статистик мэдээллээс харахад 2017 оны байдлаар нийгмийн даатгалд 43.6 мянган аж ахуйн нэгж, байгууллага, 836.5 мянган албан журмын даатгуулагч, 199.1 мянган сайн дурын даатгуулагч даатгуулсан байна. Энэ нь Монгол Улсын эдийн засгийн идэвхтэй хүн амын 76.3% буюу 1.037 мянган иргэн нийгмийн даатгалд хамрагдсан үзүүлэлт юм.

Сайн дурын хэлбэрээр даатгуулагчийн хувьд 2017 онд өмнөх жилээс 13%-иар буурсан буюу үүнээс малчдын хамралт өмнөх оноос 28%-иар буурсан үзүүлэлттэй байна. Энэхүү үзүүлэлтэд нийгмийн даатгалын талаарх мэдээллийн хүртээмж, хүн амын зорилтот бүлэгт чиглэсэн бодлого зэрэг хүчин зүйл нөлөөлж байна.

Түүнчлэн доорх хүснэгтэд харуулснаар сайн дурын даатгуулагчдыг нийгмийн даатгалын мэдээллийн санд бүртгэхдээ “ажилгүй иргэн”, ажил эрхлэлтийн байдал нь “тодорхойгүй, бусад” статусаар бүртгэгдсэн тоо харьцангуй өндөр байна. Иймд аймаг, дүүргийн нийгмийн даатгалын байгууллага нь нийгмийн даатгалд сайн дурын хэлбэрээр хамрагдаж буй иргэдийг хөдөлмөр эрхлэлтийн байдлыг үнэн зөв мэдээллийн санд оруулах ажлыг зохион байгуулах хэрэгтэй нь харагдаж байна.

Хүснэгт 8. Сайн дурын даатгуулагчийн хамралтын байдал (мян.хүн)

Ажил эрхлэлтийн байдал	Даатгуулагчийн тоо		
	2015 он	2016 он	2017 он
Хувиараа бизнес эрхлэгч	390	13,402	22,695
Гадаадын төслийн нэгжид ажилладаг иргэн	3	59	62
Жолооч (такси, тээврийн жолооч)	9	189	297
Бичил уурхай эрхлэгч	28	466	670
Газар тариалан эрхлэгч (ногоочин)	167	586	212
Малчин	216	51,515	37,051
Оюутан (бакалавр, магистр, докторант)	27	1,350	2,258
Захиргааны цалингүй чөлөө түр хугацаанд авсан иргэн	4	331	840
Гадаад улс оронд оршин суугч иргэн	57	951	1,383
Ажилгүй иргэн	744	53,416	79,414
Тодорхойгүй, бусад	181,594	105,943	51,448

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны захиалгаар Максима Консалтинг компаниас 2017 онд 2000 иргэнийг хамруулан улсын хэмжээнд зохион байгуулсан нийгмийн даатгалын салбарын хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаанд насны

бүлгийн хувьд 18-24 насны 6.3%, 25-34 насны 21.6%, 35-44 насны 21.4%, 45-54 насны 16.9%, 55-аас дээш насны 32.7% иргэн хамрагдсан байна. Нийт судалгаанд хамрагдсан иргэдийн 32.3% нь албан журмын даатгалд, 10.2% нь сайн дурын даатгалд хамрагдсан буюу нийт 42.5% нь нийгмийн даатгалд хамрагдсан үзүүлэлттэй байна.

Дээрх нийгмийн даатгалын статистик мэдээлэл, хөндлөнгийн судалгаанаас хүн амын нийгмийн даатгалын хамрагдалт, мэдээлэл авч байгаа байдлаар дараах зорилтот бүлгүүдийг тодорхойлон эдгээр бүлгүүдэд чиглэсэн мэдээллийг түгээх боломжтой. Үүнд:

1. Малчин;
2. Хувиараа хөдөлмөр эрхлэгч (бичил уурхай зэрэг улирлын чанартай ажил, үйлчилгээ эрхлэгч, чөлөөт уран бүтээлчид);
3. Ажилгүй иргэд;
4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд;
5. Гадаад улсад ажиллаж, амьдарч байгаа иргэд;
6. Оюутан, суралцагчид;
7. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчид;
8. Тэтгэврийн нас ойртсон даатгуулагчид, тэтгэвэр авагчид;
9. Ажил олгогчид;
10. Албан журмын даатгуулагч буюу ажилтан.

3.2. Зорилтот бүлгүүдэд мэдээлэл хүргэх суваг, арга хэлбэр

Дээр дурдсан нийгмийн даатгалын салбарын хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаа¹наас харахад нийгмийн даатгалын үйлчилгээний талаарх мэдээлэл авдаг эх сурвалжийн хувьд иргэд-даатгуулагчид нийгмийн даатгалын талаарх мэдээллийг телевизээс хамгийн өндөр буюу судалгаанд оролцогчдын 50 орчим хувь нь авч байна. Харин байгууллагын вэбсайт, сурталчилгааны материал, мэдээллийн самбар, нийгмийн сүлжээнээс түгээсэн мэдээлэл харьцангуй үр дүн муутай буюу мэдээллийн хүртээмж дутмаг байгааг харуулж байна.

Түүнчлэн иргэд-даатгуулагчдын нийгмийн даатгалын талаарх мэдээлэл авч байгаа эх сурвалжийн 20% нь бусдын амнаас буюу ам дамжсан яриа, 20-30% нь нийгмийн даатгалын ажилтнууд болж байгаа нь буруу ташаа мэдээлэл тарах, нийгмийн даатгалын байгууллагаар үйлчлүүлэх ачаалал үүсгэх, эргээд энэ нь үйлчилгээний чанарт сөргөөр нөлөөлж байгаа хүчин зүйл болж байна. Нийгмийн даатгалын лавлах утас нь 1%-ийн мэдээллийн эх сурвалж болж байна. Цаашид нийгмийн даатгалын лавлах утас (call center)-ны үйл ажиллагааг өргөжүүлж иргэд-даатгуулагчийн нийгмийн даатгалын талаарх мэдээлэл авах эх сурвалж болгосноор нийгмийн даатгалын байгууллагаар үйлчлүүлэгчдийн ачаалал буурч, чанар хүртээмж сайжрах, даатгуулагчийн сэтгэл ханамж нэмэгдэх боломжтой юм.

¹ Нийгмийн даатгалын салбарын хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаа, Максима Консалтинг компани, 2017 он

Хүснэгт 2. Нийгмийн даатгалын үйлчилгээний талаарх мэдээлэл авдаг эх сурвалж

№	Мэдээллийн эх сурвалж	Тэтгэврийн даатгал	Ажилгүйдлийн даатгал	Тэтгэмжийн даатгалын	ҮОМШӨ-ний даатгал	Эрүүл мэндийн даатгал	Сайн дурын даатгал
1	Байгууллагын веб хуудаснаас	7.0%	6.4%	6.1%	6.2%	8.7%	6.3%
2	Байгууллагын мэдээллийн самбар	5.2%	4.3%	3.9%	3.5%	6.8%	4.2%
3	Тараах материал, танилцуулга	5.1%	4.5%	4.6%	4.7%	6.7%	5.2%
4	Хариуцсан ажилтнаас	21.9%	17.9%	19.0%	17.0%	32.3%	22.1%
5	Лавлах утаснаас	1.0%	0.7%	0.7%	1.1%	2.8%	1.3%
6	Бусдын амнаас	22.4%	21.1%	20.3%	20.4%	24.0%	21.2%
7	Телевизийн мэдээ, нэвтрүүлэг	50.0%	42.1%	43.2%	41.3%	56.7%	43.4%
8	Нийгмийн сүлжээгээр	7.8%	7.7%	7.4%	7.2%	9.4%	7.9%
9	Сонин, сэтгүүл	2.3%	2.4%	2.1%	1.8%	3.3%	2.3%
10	Бусад мэдээллийн сайтууд	2.5%	2.3%	2.8%	2.5%	2.6%	2.3%
11	Бусад	3.5%	3.7%	3.8%	3.8%	3.5%	3.9%

Эх сурвалж: Нийгмийн даатгалын салбарын хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаа, Максима Консалтинг компани, 2017 он

Энэхүү судалгаанд нийгмийн даатгалын салбарын үйлчилгээний талаар цахим болон хэвлэмэл лавлах толь, лавлах утас, нийгмийн сүлжээний хэлэлцүүлэг зэргийг нэгдсэн систем болгон хөгжүүлж, улсын хэмжээнд өргөн агуулгаар, хүртээмжтэй сурталчилж, хэрэглэгчдийг бүрэн дүүрэн хүртээмжтэй мэдээллээр хангах ажил нэн шаардлагатай гэж дүгнэжээ.

Түүнчлэн, нийгмийн даатгалын байгууллагад цахимаар ирж байгаа санал хүсэлтийн 60 гаруй хувь нь нийгмийн даатгалын талаарх мэдээлэл авах эх үүсвэр, холбогдох хууль тогтоомжийн өөрчлөлтийн талаарх санал хүсэлт эзэлж байна.

Нийгмийн даатгалын үйлчилгээний маркетингийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ иргэд, даатгуулагчдыг зорилтот бүлэгт хуваан, тэдэнд чиглэсэн хамгийн оновчтой эх сурвалжаас мэдээлэл хүргэх, нийгмийн даатгалын хамтрагч талуудын оролцоонд тулгуурлах нь илүү үр дүнтэй гэж үзэж зорилтот бүлэгт доорх арга зам, эх сурвалжаар мэдээллийг түгээхээр тодорхойлов. Үүнд:

Зорилтот бүлэг

Мэдээлэл хүргэх суваг, арга хэлбэр

Малчин

- Нийгмийн даатгалын талаарх радиогийн зохиомжит цуврал нэвтрүүлэг бэлтгэн, түгээх (малчин телевиз зэрэг);
- Нийгмийн даатгалын талаарх хэвлэмэл танилцуулга, гарын авлага боловсруулж, түгээх;
- Сумын нийгмийн даатгалын байцаагч нар сум, багийн Засаг дарга нартай хамтран малчдад мэдээлэл хүргэх;
- Сумын нийгмийн даатгалын байцаагч нар арилжааны банкуудтай хамтран ноос, ноолуурын болон мах бэлтгэх, малын тооллого хийх зэрэг үед мэдээлэл хүргэх, шимтгэл хураах;
- Даатгуулагчийн гэрээний болон шимтгэл төлөлтийн талаарх сануулга мессеж илгээх.

<p>Хувиараа хөдөлмөр эрхлэгч (бичил уурхай зэрэг улирлын чанартай ажил, үйлчилгээ эрхлэгч, чөлөөт уран бүтээлчид зэрэг)</p>	<ul style="list-style-type: none"> - Улиралд нэг удаа нийгмийн даатгалын өдөрлөгийг зах, худалдааны төв зэрэг хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн ажлын байранд зохион байгуулах; - Ажлын байран дээр яриа, сургалт хийх, мэдээлэл өгөх, бичил уурхай эрхлэгч, чөлөөт уран бүтээлчдэд тусгайлан нийгмийн даатгалд даатгуулахын ач холбогдлын талаар сурталчлан материал бэлтгэн хүргэх; - Даатгуулагчийн гэрээний болон шимтгэл төлөлтийн талаарх сануулга мессеж илгээх.
<p>Ажилгүй иргэд</p>	<ul style="list-style-type: none"> - Нийгмийн даатгалын байгууллагад ажилгүйдлийн тэтгэмж авахаар ирэхэд даатгалын талаарх танилцуулга мэдээллийг амаар өгөх болон сурталчилгааны материал тараах; - Хөдөлмөр, халамж, үйлчилгээний байгууллага, баг, хорооны Засаг дарга, нийгмийн ажилтнаар дамжуулан ажилгүй иргэдэд даатгалын талаар мэдээлэл хүргэх.
<p>Хөгжлийн бэрхшээлтэй иргэд</p>	<ul style="list-style-type: none"> - Эмнэлэг, хөдөлмөрийн магадлал, тахир дутуугийн тэтгэврийн талаарх мэдээллийг хүргэх.
<p>Хилийн чанадад ажиллаж, амьдарч байгаа иргэд</p>	<ul style="list-style-type: none"> - Хилийн чанадад амьдарч байгаа иргэдэд нийгмийн даатгалын мэдээллийг цуврал подкаст (podcast)-аар дамжуулан хүргэх; - Хилийн чанадад амьдарч байгаа иргэдийн холбоо, нэгдэл, элчин, консулаар дамжуулан мэдээлэл хүргэх. - Оюутан, суралцагчдын нийгмийн даатгалын мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх хүрээнд эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулах; - Залуучуудын хөгжлийг дэмжих төрийн болон төрийн бус байгууллагатай хамтын ажиллагааг өргөжүүлэх замаар оюутан, суралцагчдыг мэдээллээр хангах; - Тэдний сонирхол, онцлогт тохирсон гарын авлага, танилцуулга бэлтгэн хүргэх;
<p>Оюутан, суралцагчид</p>	<ul style="list-style-type: none"> - Оюутан суралцагчдын нийгмийн даатгалын мэдлэгийг дээшлүүлэх, олон нийтийг мэдээллээр хангах, нийгмийн даатгалын тулгамдаж байгаа асуудалд тэдний анхаарлыг хандуулах, шийдэл боловсруулах зорилгоор их, дээд сургууль, коллежтэй хамтран бакалавр, магистрийн судалгааны сэдэвт нийгмийн даатгалын сэдэв оруулах, нийгмийн даатгалын байгууллагын зүгээс холбогдох тоо, мэдээллээр хангах, хамтран ажиллах. - Дунд сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд эссэ бичлэг, илтгэлийн уралдаан зарлан нийгмийн даатгалын ач холбогдлыг сурталчлан таниулах, ирээдүйн нийгмийн баталгаагаа хангах чадвартай иргэн бэлтгэх;
<p>Ерөнхий боловсролын сургуулийн сурагчид</p>	<ul style="list-style-type: none"> - ЕБС-ийн ахлах ангийн хичээлийн хөтөлбөрт туссан нийгмийн даатгалын сэдвийг баяжуулах, нэмэлт өөрчлөлт оруулах; - Сурагчдын насны онцлогт тохирсон комик ном, сэтгүүл бэлтгэн хүргэх.
<p>Тэтгэврийн нас ойртсон даатгуулагчид,</p>	<ul style="list-style-type: none"> - Тэтгэврийн нас ойртсон даатгуулагчдад баримт бичгийн бүрдлийг урьдчилан шалгуулах талаарх сануулга мессеж болон засаг захиргааны нэгж, ажил олгогчоор нь дамжуулан

тэтгэвэр авагчид	урилга илгээх; - Нийгмийн даатгалын байгууллага тэтгэврийн нас ойртсон иргэдэд тусгайлан зөвлөгөө, мэдээлэл өгөх; - Тэтгэвэр авагчдад гарын авлага бэлтгэн хүргэх.
Ажил олгогчид	- Нийгмийн даатгалын шилдэг шимтгэл төлөгчдийг сурталчлан мэдээлэх; - Томоохон аж ахуйн нэгжид нийгмийн даатгалын мэдээлэл түгээх сургагч багш, төлөөлөгч бэлтгэн ажиллуулах.
Албан журмын даатгуулагч буюу ажилтан	- Даатгуулагчдад нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн мэдээлэл авах, хяналт тавих боломжийг сурталчлан таниулах.

3.3. Олон нийтэд чиглэсэн үйл ажиллагаа

Нийгмийн даатгалын байгууллага нь мэргэжлийн байгууллагын хувьд олон нийтэд нийгмийн даатгалын талаарх мэдээллийг шуурхай, үнэн зөв хүргэх үүрэгтэй ба дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Даатгуулагч, олон нийтийн нийгмийн даатгалд даатгуулах итгэлийг нэмэгдүүлэх, нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааг ил тод тайлагнах, мэдээлэх зорилгоор “нийгмийн даатгалын үйл ажиллагааны тайлан-илтгэл”-ийг жил бүр хэвлэмэл болон цахим хэлбэрээр гаргах;
- Нийгмийн сүлжээний хэрэгслээр олон нийтэд хүрч байгаа нийгмийн даатгалын талаарх мэдээлэлд дүн шинжилгээ хийх, эргэх холбоогоор хангах;
- Ирээдүйд үүсэх аливаа сөрөг нөхцөл байдлаас урьдчилан сэргийлэх, судалгаа, нотолгоонд тулгуурласан шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлж нийгмийн даатгалын сангийн өнөөгийн болон ирээдүйн төлөв байдлын талаар цуврал нийтлэл бэлтгэн өдөр тутмын сонин, цахим контентоор олон нийтэд хүргэх, мэдлэгтэй, мэдээлэлтэй даатгуулагчийг бэлтгэх;
- Олон нийтэд нийгмийн даатгалын талаарх мэдээллийг сурталчлах, тэдний сонирхсон асуултад хариулах, санал хүсэлтийг сонсох зорилгоор олон нийтийн лекц, семинар, нээлттэй хэлэлцүүлгийг тогтмол зохион байгуулах;
- Нийгмийн сүлжээний хэрэгсэл ашиглан нийгмийн даатгалын ач холбогдлыг сурталчлан таниулах, цаг үеийн мэдээллээр хангах зорилгоор цахим контентыг бэлтгэх, мэдээллийг тодорхой давтамжтайгаар “мэдээллийн нэг эх үүсвэрээс” зарчим баримтлан орон даяар нэг цаг хугацаанд хүргэх;
- Нийгмийн даатгалын талаар олон нийтийн мэдээлэл авах эх үүсвэр болох байгууллагын вэбсайт, гар утасны аппликейшн болон бусад мэдээллийн хэрэгслийг сурталчлан таниулах;
- Нийгмийн даатгалын талаарх мэдээлэл түгээхэд олонд хүндлэгдсэн хүмүүсээр дамжуулан хүргэх. Тэднийг нийгмийн даатгалын “нүүр царай”-аар хоногшуулах буюу нийгмийн даатгалын талаарх мэдээллээр хангах албан уулзалтууд зохион байгуулах, тэдний хөтлөн явуулдаг нийтлэл, ярилцлага, твиттер, фэйсбүүк, блог, влог, подкаст зэрэг хэрэгслээр олон нийтэд мэдээллийг хүргэхэд хамтран ажиллах;
- Хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран телевиз, радиогийн зорилтот нэвтрүүлэг, кино, уралдаан бэлтгэн олон нийтэд хүргэх;

- Нийгмийн даатгалын лавлах утсаар мэдээлэл түгээх, даатгуулагчийн санал хүсэлтэд шуурхай хариулах үйл ажиллагааг сайжруулах;
- Нийгмийн даатгалын хууль тогтоомж, үйл ажиллагааг сурталчлан таниулах нээлттэй өдөрлөг, явуулын үйлчилгээ зэрэг үйл ажиллагааг зохион байгуулж хэвших;
- Нийгмийн даатгалын байгууллагаас менежментийн болон нийгмийн даатгалын үйлчилгээ, үйл ажиллагааг сайжруулах бодлого, хэрэгжүүлж байгаа ажлын талаар олон нийтэд тогтмол мэдээлэх хүргэх;
- Мэдээллийг олон нийтэд түгээн дэлгэрүүлэхэд хэвлэл мэдээллийн ажилтнуудын оролцоог дээшлүүлэх, тэднийг сургах, тогтмол мэдээллээр хангах.

3.4. Нийгмийн даатгалын байцаагч, ажилтнуудад чиглэсэн үйл ажиллагаа

Энэхүү хөтөлбөрийн дотоод хэрэглэгч нь нийгмийн даатгалын байгууллагын нийт ажилтнууд бөгөөд тэдэнд чиглэсэн дараах үйл ажиллагааг зохион байгуулна. Үүнд:

- Нийгмийн даатгалын талаарх бодлого, шийдвэрийн талаарх мэдээллийг олон нийтэд шуурхай, үнэн зөв, ижил түвшинд хүргэх зорилгоор нийгмийн даатгалын байгууллага хооронд мэдээлэл дамжуулах процесс зураглалыг боловсруулах, мөрдөж хэвших;
- Нийгмийн даатгалын ажилтнуудын мэргэжлийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх ажил мэргэжлийн уралдаан болон онол практикийн бага хурлыг тодорхой давтамжтай зохион байгуулах;
- Нийгмийн даатгалын байцаагч, ажилтнуудыг нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийг нэг мөр ойлголтоор хэрэгжүүлэх, мэдлэг, ур чадварыг нь дээшлүүлэх, тэдний хэрэгцээнд нийцсэн тасралтгүй сургалтын тогтолцоог бүрдүүлэх;
- Нийгмийн даатгалын байцаагч, ажилтнуудын нийгмийн даатгалын үйл ажиллагаа, үйлчилгээг сайжруулахаар гаргасан шинэ санал, санаачилгыг хэрэгжүүлэх, урамшуулах нөхцөлийг бүрдүүлэх.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ МАРКЕТИНГИЙН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

4.1. Нөөц, эх үүсвэр

Нийгмийн даатгалын маркетингийн хөтөлбөрийг дараах байгууллага, хамтын ажиллагааны хүрээнд доорх санхүүгийн нөөцөд тулгуурлан хэрэгжүүлнэ. Үүнд:

- Нийгмийн даатгалын байгууллагын төсөв;
- Олон улсын хамтын ажиллагааны байгууллага, төсөл, хөтөлбөрийн санхүүжилт;
- Нийгмийн хариуцлагын хүрээнд аж ахуйн нэгж, байгууллагын санхүүжилт;

- Төрийн байгууллагуудын хамтын ажиллагааны хүрээнд;
- Төрийн бус байгууллагын дэмжлэг оролцоо;
- Бусад эх үүсвэр зэрэг болно.

4.2. Зохион байгуулалт

Нийгмийн даатгалын үйлчилгээний маркетингийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө (Хавсралт 1)-ны дагуу Нийгмийн даатгалын маркетингийн дунд хугацааны хөтөлбөрийг 2019-2022 онд буюу 4 жилийн хугацаанд хэрэгжүүлнэ.

Хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөөг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргаар батлуулан хэрэгжилтийг салбарын хэмжээнд зохион байгуулж, гүйцэтгэлийн тайланг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын зөвлөлөөр хэлэлцэнэ.

Нийгмийн даатгалын ерөнхий газар нь маркетингийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд нэгдсэн удирдлагаар хангаж, аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын байгууллагууд нь үйл ажиллагааны төлөвлөгөөнд нийцүүлэн жил бүрийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг хангана.

ТАВДУГААР БҮЛЭГ. НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ МАРКЕТИНГИЙН ХӨТӨЛБӨРИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

Маркетингийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг сайжруулах, алдаа гарах эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, засах болон үр дүнг үнэлэх зорилгоор хяналт-шинжилгээ, үнэлгээг тогтмол хийнэ. Хөтөлбөрийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээ (Хавсралт 2. Нийгмийн даатгалын маркетингийн хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээний суурь шалгуур үзүүлэлт) нь дараах хүрээнд зохион байгуулагдана. Үүнд:

- Хөтөлбөрийн төлөвлөгөөний хэрэгжилтийн байдал;
- Хэрэгжилтийн явцад төлөвлөснөөс өөр өөрчлөлт гарсан байдал;
- Хөтөлбөрийн тавьсан зорилго, хүлээсэн үр дүнд хүрсэн байдал;
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд нийгмийн даатгалын хамтрагч талууд, ажилтнуудаас санал хүсэлт гарсан байдал;
- Хөтөлбөрийн хүрээнд тодорхойлсон зорилтот бүлэгт үр дүн хүрсэн байдал, тэдний нийгмийн даатгалын талаарх мэдлэг, хандлага, ойлголтод нөлөөлсөн байдал, хамралтын түвшин, хэрэгжүүлсэн арга зам, байршил, үйл ажиллагаа тохиромжтой байдал зэргийг харгалзан үнэлгээг зохион байгуулна.

**ХАВСРАЛТ 1. НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ МАРКЕТИНГИЙН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Үйл ажиллагаа	Хэрэгжүүлэх түвшин			Хэрэгжүүлэх хугацаа				Үр дүн	Шалгуур үзүүлэлт	Шаардагдах хөрөнгийн эх үүсвэр
	Төв	Нийслэл	Орон нутаг	2019 он	2020 он	2021 он	2022 он			
Зорилт 1: Нийгмийн даатгалын зорилтот бүлэг тус бүрийг тодорхойлж, нийгмийн даатгалын зарчим, төрөл, түүний ач холбогдлын талаарх мэдлэг ойлголтыг дээшлүүлэх мэдээллийн багцуудыг боловсруулах, тэднийг нийгмийн даатгалд хамруулах үйл ажиллагааг идэвхжүүлэх	Хүрэх үр дүн: Зорилтот бүлэг бүрийн онцлог шинж, нийгмийн даатгалын талаарх мэдлэг, хандлага, ойлголтыг судлан, мэдээллийн багцуудыг боловсруулан хүргүүлэх, үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлснээр хамралтыг нэмэгдүүлсэн байна.									
1.1. Хүн амын болон зорилтот бүлгийн нийгмийн даатгалын талаарх мэдлэг, хандлага, ойлголтын түвшин тодорхойлох судалгааг тогтмол зохион байгуулах;	√	√	√	+	+	+	+	Сэтгэл ханамжийн судалгааг бүх түвшинд зохион байгуулж, үр дүнгийн тайлан боловсруулсан байна.	- Судалгааны асуумж - Үр дүнгийн тайлан	- НДЕГ - НДХ-үүд
1.2. Тодорхойлсон зорилтот бүлэгт зориулан мэдээллийн багц (гарын авлага, комик ном, зурагт хуудас, контент зэрэг)-ыг олон улсын хамтын ажиллагааны байгууллагуудтай хамтран боловсруулах, хэвлүүлэх, түгээх;	√			+	+	+	+	Зорилтот бүлгүүдийн онцлог тохирсон мэдээллийн багцыг боловсруулж, хүргэсэн байна.	- Боловсруулсан мэдээллийн багцын тоо, төрөл	- НДЕГ - Олон улсын байгууллага төсөл, хөтөлбөр
1.3. Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулах болон шимтгэл төлөх процессыг хялбарчлах, сонголтыг нэмэгдүүлэх;	√	√	√	+	+	+	+	Иргэдийн нийгмийн даатгалд даатгуулах, шимтгэл төлөх процессыг хялбарчлан сонголтыг нэмэгдүүлэх замаар хамралтыг нэмэгдүүлсэн байна.	- Зохион байгуулж, хэрэгжүүлсэн ажлын тоо, төрөл	- НДЕГ - НДХ-үүд

1.4. Нийгмийн даатгалын үйлчилгээний чанарыг үнэлэх, үнэлгээний мөрөөр үйл ажиллагааг сайжруулах арга хэмжээг зохион байгуулах;	√	√	√	+	+	+	+	Үйлчилгээний чанарыг хэмжих servqual зэрэг загвар, арга хэрэгслээр үнэлгээг зохион байгуулж, үр дүнгийн мөрөөр холбогдох арга хэмжээг зохион байгуулснаар үйлчилгээний чанар дээшилсэн байна.	- Үнэлгээний тайлан - Зохион байгуулсан ажлын тоо	- НДЕГ - НДХ-үүд
1.5. Нийгмийн даатгалын хууль тогтоомж, үйл ажиллагааг сурталчлан таниулах нээлттэй өдөрлөг, явуулын үйлчилгээ зэрэг үйл ажиллагааг зохион байгуулж хэвших;	√	√	√	+	+	+	+	Олон нийтийн дунд нийгмийн даатгалын талаарх мэдлэг, мэдээлэл сайжирч, хамралт нэмэгдсэн байна.	- Зохион байгуулсан арга хэмжээний тоо, төрөл	- НДЕГ - НДХ-үүд
1.6. Олон нийтийн дундах нийгмийн даатгалын талаарх мэдлэг, хандлага, ойлголтод дүн шинжилгээ хийх, буруу ойлголтыг залруулж, мэдээллийг үнэн зөв хүргэх.	√				+	+	+	Олон нийтийн дундах нийгмийн даатгалын талаарх буруу ташаа ойлголтыг судлах, түүнийг залруулж үнэн зөв мэдээлэл хүргэсэн байна.	- Хэрэгжүүлсэн ажлын тоо	- НДЕГ
ЗОРИЛТ 2: <i>Олон нийтэд нийгмийн даатгалын ач холбогдлыг ойлгуулан таниулах, нийгмийн даатгалд даатгуулах хандлагыг бий болгох зорилгоор мэдээлэл хүргэх сувгийг тодорхойлох, сонгох, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, ажил олгогч, олон улсын хамтын ажиллагааны байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах, тэдний оролцоог нэмэгдүүлэх, хамтын ажиллагааг бэхжүүлэх</i>								Хүрэх үр дүн: Нийгмийн даатгалын ач холбогдлыг сурталчлан таниулах мэдээллийн багцуудыг маркетингийн хөтөлбөрийн хүрээнд тодорхойлсон суваг, аргачлалаар хамтрагч талуудын оролцоотойгоор зорилтот бүлэг болон олон нийтэд түгээн хоногшуулснаар хүн амын нийгмийн даатгалын талаарх ойлголт дээшилсэн байна.		
2.1. Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч, ажилгүй иргэд, гадаад улсад ажиллаж, амьдарч байгаа иргэд, оюутан, суралцагчид, ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, тэтгэврийн нас ойртсон даатгуулагчид, тэтгэвэр авагчид, ажил олгогчид, албан журмын даатгуулагч буюу ажилтан	√	√	√	+	+	+	+	Нийгмийн даатгалын мэдээллийн багцуудыг зорилтот бүлгүүдэд түгээж, нийгмийн даатгалын ач холбогдлыг олон нийтэд таниулсан байна.	- Түгээсэн мэдээлэл, сувгийн тоо, төрөл	- НДЕГ - НДХ-үүд - Хамтрагч талууд - Олон улсын байгууллага төсөл, хөтөлбөр

зэрэг зорилтот бүлгүүдэд нийгмийн даатгалын талаарх мэдээллийг сонгосон мэдээллийн суваг, аргачлалаар хүргэх;												
2.2. “Нийгмийн даатгалын үйл ажиллагааны тайлан-илтгэл”-ийг хэвлэмэл болон цахим хэлбэрээр гаргах;	√			+	+	+	+		Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааг ил тод тайлагнан мэдээлж хэвшин, даатгуулагч, олон нийтийн итгэлийг нэмэгдүүлсэн байна.	- Цахим болон хэвлэмэл байдлаар гаргасан тайлан-илтгэлийн тоо	- НДЕГ	
2.3. Нийгмийн даатгалын талаар цуврал нийтлэл бэлтгэн өдөр тутмын сонин, цахим контентоор олон нийтэд хүргэх;	√			+	+	+	+		Нийгмийн даатгалын тогтолцоо, үйл ажиллагааны талаарх аливаа нөхцөл байдлыг даатгуулагч олон нийтэд мэдээлэх, судалгаа, нотолгоонд тулгуурласан шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлж нийгмийн даатгалын сангийн өнөөгийн болон ирээдүйн төлөв байдлын талаарх мэдээллийг олон нийтэд хүргэсэн байна.	- Нийтэлсэн мэдээллийн тоо, төрөл	- НДЕГ	
2.4. Олон нийтийн лекц, семинар, нээлттэй хэлэлцүүлгийг зохион байгуулах;	√	√	√	+	+	+	+		Олон нийтэд нийгмийн даатгалын ач холбогдол болон цаг үеийн асуудлаарх мэдээллийг түгээн сурталчилж, тэдний санал хүсэлтийг хүлээн авах үйл ажиллагааг хэвшүүлсэн байна.	- Зохион байгуулсан арга хэмжээний тоо, төрөл	- НДЕГ - НДХ-үүд	
2.5. Хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй хамтран телевиз, радиогийн зорилтот нэвтрүүлэг, кино, уралдаан бэлтгэн олон нийтэд хүргэх;	√	√	√	+	+	+	+		Олон нийтэд нийгмийн даатгалын талаарх мэдээллийг хүргэх, ач холбогдлыг нь ойлгуулан таниулах зорилгоор телевиз, радиогийн зорилтот бүтээл бэлтгэн хүргэсэн байна.	- Зохион байгуулсан арга хэмжээний тоо, төрөл	- НДЕГ - НДХ-үүд - Хамтрагч талууд - Олон улсын байгууллага	

											төсөл, хөтөлбөр	
2.6. Нийгмийн даатгалын лавлах утсаар мэдээлэл түгээх, даатгуулагчийн санал хүсэлтэд шуурхай хариулах үйл ажиллагааг сайжруулах;	√			+	+					Лавлах утасны ажиллагааг сайжруулах замаар даатгуулагчдад мэдээллийг түрхэн шуурхай түгээх, НДХ-үүдийн ачааллыг бууруулсан байна.	- Хэрэгжүүлсэн ажлын тоо, төрөл	- НДЕГ - Олон улсын байгууллага төсөл, хөтөлбөр
2.7. Нийгмийн даатгалын талаарх мэдээллийг олон нийтэд нөлөө бүхий олны танил хүмүүсээр дамжуулан хүргэх хүрээнд холбогдох уулзалт, ярилцлага зохион байгуулах, хамтран ажиллах;	√			+	+					Нийгмийн даатгалын мэдээллийг хүргэхдээ олны танил хүмүүстэй хамтран ажилласан байна.	- Зохион байгуулсан арга хэмжээний тоо, төрөл	- НДЕГ - Олон улсын байгууллага төсөл, хөтөлбөр
2.8. Хэвлэл мэдээллийн ажилтнуудыг сургах, тогтмол мэдээллээр хангах;	√	√	√	+	+	+	+			Олон нийтэд нийгмийн даатгалын талаарх мэдээллийг түгээхэд сэтгүүлч, уран бүтээлчидтэй хамтын ажиллагааг өргөжүүлсэн байна.	- Хэрэгжүүлсэн ажлын тоо, төрөл	- НДЕГ - НДХ-үүд - Хамтрагч талууд
2.9. Хөдөлмөр, халамж үйлчилгээний, залуучуудын зэрэг нийгмийн хамгааллын салбарын болон холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах;	√	√	√	+	+	+	+			Харилцан мэдээлэл солилцох, үйл ажиллагаагаа уялдуулах чиглэлээр хамтран ажилласан байна.	- Хэрэгжүүлсэн ажлын тоо, төрөл	- НДЕГ - НДХ-үүд - Хамтрагч талууд
2.10. Үйлдвэрчний эвлэл, ажил олгогчдын холбоо болон холбогдох төрийн бус байгууллагууд, олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн төсөл хөтөлбөрүүдийн төлөөлөлтэй уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулан хамтран ажиллах;	√			+	+					Нийгмийн даатгалын талаарх мэдээллийг олон нийтэд хүргэх, үйл ажиллагааг сайжруулахад хамтрагч талууд, олон улсын хамтын ажиллагааны байгууллагуудтай хамтын ажиллагааг бэхжүүлсэн байна.	- Зохион байгуулсан арга хэмжээний тоо, төрөл	- НДЕГ - Хамтрагч талууд - Олон улсын байгууллага төсөл, хөтөлбөр
2.11. Нийгмийн даатгалын хамтрагч	√			+	+	+	+			Нийгмийн даатгалын	- Зөвлөлдөх	- НДЕГ

талуудтай санал солилцох зөвлөлдөх уулзалт зохион байгуулах, ажлын уялдаа холбоог хангах.								хамтрагч талуудтай санал солилцох зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулж, ажлын уялдаа холбоог хангасан байна.	уулзалтаас гарсан зөвлөмж, тайлан	- Хамтрагч талууд - Олон улсын байгууллага төсөл, хөтөлбөр
ЗОРИЛТ 3: <i>Нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллага, ажилтны зүгээс нийгмийн даатгалын үйлчилгээг олон нийт, даатгуулагчдад мэдээлэх, сурталчлан таниулах, ур чадварыг дээшлүүлэх</i>								Хүрэх үр дүн: Нийгмийн даатгалын байгууллага, байцаагч, ажилтнуудаас нийгмийн даатгалын маркетингийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх замаар хөтөлбөрийн хэрэгжилт хангагдсан байна.		
3.1. Нийгмийн даатгалын байгууллага хооронд мэдээлэл дамжуулах процесс зураглалыг боловсруулах, мөрдөж хэвших;	√	√	√	+	+	+	+	Нийгмийн даатгалын талаарх бодлого, шийдвэр, цаг үеийн мэдээллийг олон нийтэд шуурхай, үнэн зөв, ижил түвшинд хүргэх зорилгоор НДЕГ, ННДГ, НДХ хооронд мэдээлэл дамжуулах зураглал боловсруулан мөрдөж хэвшсэн байна.	- Батлагдсан зураглал	- НДЕГ - ННДГ - НДХ-үүд
3.2. Ажил мэргэжлийн уралдаан болон онол практикийн бага хурлыг тодорхой давтамжтай зохион байгуулах;	√	√	√		+		+	Нийгмийн даатгалын ажилтнуудын мэргэжлийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх ажил мэргэжлийн уралдаан, онол практикийн бага хурлыг зохион байгуулсан байна.	- Зохион байгуулсан арга хэмжээний тоо, төрөл	- НДЕГ - ННДГ - НДХ-үүд - Олон улсын байгууллага төсөл, хөтөлбөр
3.3. Нийгмийн даатгалын байцаагч, ажилтнуудыг нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийг нэг мөр ойлголтоор хэрэгжүүлэх, мэдлэг, ур чадварыг нь дээшлүүлэх, тэдний хэрэгцээнд нийцсэн тасралтгүй	√	√	√	+	+	+	+	Нийгмийн даатгалын байцаагч, ажилтнуудыг нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийг нэг мөр ойлголтоор хэрэгжүүлэх, мэдлэг, ур чадварыг нь	- Зохион байгуулсан арга хэмжээний тоо, төрөл	- НДЕГ - ННДГ - НДХ-үүд - Олон улсын байгууллага төсөл,

сургалтын тогтолцоог бүрдүүлэх;								дээшлүүлэх тогтолцоог байна.	сургалтын бүрдүүлсэн		хөтөлбөр
3.4. Нийгмийн даатгалын байцаагч, ажилтнуудын нийгмийн даатгалын үйл ажиллагаа, үйлчилгээг сайжруулах шинэ санал, санаачилга гаргах, урамшуулах нөхцөлийг бүрдүүлэх;	√	√	√	+	+	+	+	Нийгмийн даатгалын байгууллагад удирдлагын хэрэгжүүлэх байцаагч, санал, санаачилга бүтээмж хөтөлбөрийг байна.	Чанарын тогтолцоог хүрээнд ажилтнуудын гаргах дээшлүүлэх хэрэгжүүлсэн	- Зохион байгуулсан арга хэмжээний тоо, төрөл - Гаргасан болон хэрэгжүүлсэн саналын тоо, төрөл	- НДЕГ - ННДГ - НДХ-үүд
3.5. Нийгмийн даатгалын байгууллагын байцаагч, ажилтнуудад орон нутгийн хүн амд нийгмийн даатгалын талаарх мэдээллийг түгээхэд шаардлагатай дэмжлэг тусалцаа үзүүлэх, маркетингийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх сургалт зохион байгуулах;	√	√		+	+	+	+	Орон нутгийн хүн амд нийгмийн даатгалын талаарх мэдээллийг түгээхэд шаардлагатай дэмжлэг тусалцаа үзүүлэх, мэргэжил арга зүйн дэмжлэг тусалцаа үзүүлж ажилласан байна.		- Хэрэгжүүлсэн ажлын тоо, төрөл	- НДЕГ - ННДГ - НДХ-үүд
3.6. Нийгмийн даатгалын маркетингийн хөтөлбөрийн явцын хэрэгжилтэд хяналт тавин цаашид сайжруулах зөвлөмжөөр хангах.	√	√	√		+		+	Нийгмийн даатгалын маркетингийн хөтөлбөрийн явцын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж, тайлан зөвлөмж гаргасан байна.		- Маркетингийн хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан	- НДЕГ - ННДГ - НДХ-үүд

**ХАВСРАЛТ 2. НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ МАРКЕТИНГИЙН ХӨТӨЛБӨРИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ СУУРЬ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ**

Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин (2018 он)	2019 онд хүрэх түвшин	2020 онд хүрэх түвшин	2021 онд хүрэх түвшин	2022 онд хүрэх түвшин
Хөтөлбөрийн зорилго: хүн амын нийгмийн даатгалын талаарх мэдлэг, хандлага, ойлголтыг дээшлүүлэх, төлөвшүүлэх, нийгмийн даатгалд даатгуулагчдын хамралтыг нэмэгдүүлэх.					
Нийгмийн даатгалд албан журмын даатгуулагчдын хамралтын хувь	639 820 хүн	Хамралтыг суурь түвшнөөс 3-аас доошгүй хувиар нэмэгдүүлэх	Хамралтыг 2019 оноос 3-аас доошгүй хувиар нэмэгдүүлэх	Хамралтыг 2020 оноос 3-аас доошгүй хувиар нэмэгдүүлэх	Хамралтыг 2021 оноос 3-аас доошгүй хувиар нэмэгдүүлэх
Сайн дурын даатгуулагчийн хамралтын хувь	194 418 хүн	Хамралтыг суурь түвшнөөс 10 хувиар нэмэгдүүлэх	Хамралтыг 2019 оноос 10-аас доошгүй хувиар нэмэгдүүлэх	Хамралтыг 2020 оноос 10-аас доошгүй хувиар нэмэгдүүлэх	Хамралтыг 2021 оноос 10-аас доошгүй хувиар нэмэгдүүлэх
Олон нийтийн нийгмийн даатгалын талаарх мэдлэг, ойлголтын түвшин	35% нь нийгмийн даатгалын талаар хангалттай мэдээлэл авч чаддаггүй (2017 он)	Мэдээлэл авч чадахгүй иргэдийн хувийг 30%-д хүргэн бууруулах	Мэдээлэл авч чадахгүй иргэдийн хувийг 25%-д хүргэн бууруулах	Мэдээлэл авч чадахгүй иргэдийн хувийг 20%-д хүргэн бууруулах	Мэдээлэл авч чадахгүй иргэдийн хувийг 15%-д хүргэн бууруулах
Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн түвшин	70% (2017 он)	75%	80%	85%	90%

--oOo--